



**БАГАНУУР ДҮҮРГИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8/01

Улаанбаатар хот

Бүтэц орон тоо, албан тушаалын
чиг үүрэг, цалингийн сүлжээ батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.10, Хөдөлмөрийн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.3 дугаар хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/757 дугаар захирамж, Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтэц, орон тоог 1 дүгээр хавсралтаар, албан тушаалын чиг үүргийг 2 дугаар хавсралтаар, цалингийн сүлжээг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Цалингийн сүлжээ шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан ажилтнуудад цалинг бодож олгохыг нягтлан бодогч /Л.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.
3. Газрын даргын энэ тушаалыг 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ны А/04, 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/12 дугаар тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН